



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар A/1133

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн албан ёсны мэдээллийн [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) цахим хуудас ажиллуулах журмыг 1 дүгээр, цахим хуудасны мэдээллийн цэсийг хариуцан, тухай бүр шинэчлэл хийх байгууллага, нэгжийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангаж, мэдээ, мэдээлэл оруулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул), Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (Б.Давааням)-т тус тус даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СҮМЬЯАБАЗАР



1110204862

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
09 09 2023 сарын 25-ны өдрийн  
11:11:11 захирамжийн  
1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН АЛБАН ЁСНЫ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ  
ХУУДАС АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг нийслэлийн [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) цахим хуудсанд байршуулах, түгээх, ашиглах, цахим хуудасны хэвийн үйл ажиллагаа болон байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг энхчүү журмаар зохицуулна.

Хоёр. Мэдээллийг цахим хуудсанд байршуулах,  
мэдээллийн сан үүсгэх, түгээх

2.1. Нийслэлийн мэдээ, мэдээллийн албан ёсны [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) цахим хуудсанд хууль, журамд заасан мэдээллийг ойлгомжтой, цэгтэй, хүртээмжтэй байдлаар байршуулж, олон нийтэд түгээнэ.

2.2. Цахим хуудсанд мэдээлэл оруулах, өөрчлөх, устгах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий Мэдээллийн ил тод байдал, цахим хуудас хариуцсан мэргэжилтэн (цаашид “мэргэжилтэн” гэх)-ийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар тус тус томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

2.3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс цаг үеийн үйл явдлын мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулах чиг үүргийг гүйцэтгэнэ.

2.4. Цахим хуудсанд байршуулах мэдээллийг тухайн байгууллагын удирдлага хянаж баталгаажуулсан байх бөгөөд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн холбогдох мэргэжилтэнд хүргүүлнэ.

2.5. Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн үнэн, зөвийг тухайн мэдээллийг боловсруулсан байгууллага хариуцна.

2.6. Энэ журмын 2.2-т заасан мэргэжилтэн мэдээллийг цахим хэлбэрт оруулан, татаж авах боломжтой, ойлгомжтой байдлаар цахим хуудсанд байршуулж, мэдээллийн сан үүсгэнэ.

2.7. Цахим хуудсанд байршуулах мэдээлэл нь хэл зүйн болон утга зүйн алдаагүй байх бөгөөд үүсэх хариуцлагыг мэдээлэл боловсруулсан байгууллагын удирдлага хариуцна.

2.8. Цахим хуудсанд хариуцсан байгууллага, албан тушаалтан холбогдох хуульд заасан хугацаанд мэдээллийг бүрэн оруулах үүрэгтэй.

2.9. Цахим хуудсанд байршуулах мэдээлэл нь цаасан суурьтай болон фото, график, файл, видео дүрс хэлбэрээр байна.

2.10.Овор хэмжээ ихтэй дуу, дүрс бүхий мэдээлэл, MS Word-ooc бусад форматаар оруулах шаардлагатай контентуудыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын холбогдох мэргэжилтэн цахим хуудсанд байршуулна.

2.11.Мэдээллийн санд оруулах цахим бичиг, мэдээллийг боловсруулахдаа “Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо”, “Кирилл болон монгол үсгийн нэгдсэн код” MNS 5552:2005 стандартыг мөрдөнө.

**Гурав.Цахим хуудасны мэдээллийн сангийн хадгалалт,  
хамгаалалтын найдвартай байдлыг хангах**

3.1.Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бүрдүүлэхдээ MNS ISO 17799:2007, MNS ISO/IEC 27001:2009, MNS ISO/IEC 13335:2009 стандартыг мөрдөнө.

3.2.Цахим хуудасны техникийн найдвартай, аюулгүй ажиллагааг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар хариуцна.

3.3.Цахим хуудсанд нэвтрэх эрх (нууц үг) нь албаны нууцад хамаарах бөгөөд уг эрхийг энэ журмын 2.2-т заасан мэргэжилтэн эзэмшинэ.

3.4.Энэ журмын 2.2-т заасан мэргэжилтэн цахим хуудаст нэвтрэх эрх (нууц үг)-ийг бусдад үндэслэлгүйгээр шилжүүлэх, задруулахыг хориглоно.

3.5.Цахим хуудсанд нэвтрэх эрх бүхий мэргэжилтэн өөр ажил, албан тушаалд томилогдсон тохиолдолд Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын холбогдох мэргэжилтэн цахим хуудсанд нэвтрэх эрх (нууц үг)-ийг өөрчлөн, дараагийн ажилтанд зохих журмын дагуу хүлээлгэн өгнө.

3.6.Энэ журмын 2.2-т заасан мэргэжилтэн цахим хуудасны систем болон цахим мэдээллийн архив бүртгэлийн автоматжуулсан системд нэвтрэх эрх (нууц үг)-ийн нууцлалыг хангах үүрэг хүлээнэ.

3.7.Цахим хуудсанд техникийн алдаа, аюулгүй байдлын зөрчил, саатал гарсан нөхцөлд шалтгааныг нь тодруулан, шаардлагатай гэж үзвэл төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэж, хамтран ажиллана.

**Дөрөв.Цахим хуудасны мэдээллийн сангийн тасралтгүй  
үйл ажиллагааг хангах**

4.1.Цахим хуудсанд мэдээлэл байршуулах, шинэчлэх, өөрчлөх, устгах эрхийг албан ёсны эх сурвалжийг үндэслэн энэ журмын 2.2-т заасан мэргэжилтэн эзэмшинэ.

4.2.Мэдээллийн ил тод байдал, цахим хуудас хариуцсан мэргэжилтэн холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллийг хуулиар болон энэ журамд заасан хугацаанд шинэчилж, цахим хуудасны хэвийн үйл ажиллагаанд хяналт тавина.

4.3.Цахим хуудаснаас мэдээллийг иргэн, хуулийн этгээд ойлгомжтой байдлаар шууд, саадгүй авах боломжийг бүрдүүлж, тасралтгүй хэвийн ажиллуулах нөхцөлийг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар хариуцан бүрдүүлнэ.

**Тав.Цахим хуудсаар дамжуулан гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдол,  
мэдээллийг шийдвэрлэх**

5.1.Цахим хуудсанд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийг дараах байдлаар хуваарилан зохих журмын дагуу шийдвэрлэнэ:

5.1.1.нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн харьяа байгууллагын үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын асуудал хариуцсан хэлтэс, албан тушаалтан,

5.1.2.албан хаагчидтай холбоотой мэдээллийг тухайн байгууллага болон Ёс зүйн зөвлөл.

5.2.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэлд хуулийн хугацаанд багтаан шуурхай хариу өгч шийдвэрлэнэ.

5.3.Цахим хуудсаар ирүүлсэн өргөдөл, гомдол нь Иргээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд энэ журмын 5.1-д заасан байгууллагад шилжүүлэн, хууль тогтоомж, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

#### Зургаа.Хариуцлага, хяналт

6.1.Цахим хуудсанд байршуулах мэдээллийн эх сурвалж, бодит байдлыг тухайн мэдээллийг боловсруулж, баталгаажуулсан байгууллага, албан тушаалтан хариуцна.

6.2.Цахим хуудсанд хандсан иргэдийн тоог улирал бүр гаргаж, тоймоор мэдээлнэ.

6.3.Энэ журмын 6.2-т заасан мэдээлэлд дараах статистик тоо баримтыг оруулж, өмнөх улиралтай харьцуулан дүгнэсэн байна:

6.3.1.нийт хандалтын тоо;

6.3.2.хамгийн их хандалт авсан мэдээ, контент;

6.3.3.цахим хуудсаар ирсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлын тоо, түүнийг шийдвэрлэсэн байдал;

6.3.4.тухайн улиралд байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийн тоо.

6.4.Энэ журмын 6.3-т заасан статистик мэдээлэлд тулгуурлан цахим мэдээллийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах үүргийг холбогдох байгууллагууд хариуцаж, үйл ажиллагаандаа тусгана.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
сарын 11-ны өдрийн  
захирамжийн  
2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН WWW.ULAANBAATAR.MN ЦАХИМ ХУУДАСНЫ  
ЦЭС ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА, НЭГЖИЙН ЖАГСААЛТ

Д/ д	Ерөнхий цэс	Дэд цэс	Хариуцах хэлтэс, байгууллага	Тайлбар
1	Хотын тухай	- Удирдлагууд - Эрхэм зорилго	НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Мэдээллийг тухай бүрд шинэчлэх
		- Хотын түүх - Хотын үе үеийн дарга нар - Хотын засаг захиргааны нэр	Нийслэлийн Архивын газар	
		- Гадаад харилцаа	НЗДТГ-ын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	
2	Мэдээ, мэдээлэл	- Цаг үеийн мэдээ, - Live, - Харьяа газрын мэдээ, - Ярилцлага - Подкаст - Хэвлэлийн тойм, - Фото сурвалжилга, - Зар мэдээ, - Постер	НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс	Мэдээллийг тогтмол шинэчлэх
3	Хууль, эрх зүй	- Хууль тогтоомж, - Тогтоол шийдвэр - Нийслэлийн Засаг даргын захирамж, хэрэгжилт - Нийслэлийн шуурхай	НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс  НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс,  НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Мэдээллийг тогтмол шинэчлэх
		- Оюуны өмч	НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс	
4	Авлигын эсрэг шинэтгэл	- Авлигын эсрэг мэдээлэл - Хяналт, шалгалт	НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс  НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Мэдээллийг тухай бүрд шинэчлэх
		- Тендер	НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс  Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар  Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар  Эрх шилжсэн байгууллагууд	

		<ul style="list-style-type: none"> <li>- Сул ажлын байр</li> </ul>	<p>НЭДТГ-ЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ТАСАГ</p> <p>НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГАУУД</p>	
		<ul style="list-style-type: none"> <li>- Төлөөлөн удирдах зөвлөл</li> </ul>	<p>НИЙСЛЭЛИЙН ΘӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР</p> <p>ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛТЭЙ БАЙГУУЛЛАГАУУД</p>	
		<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох хууль, тогтоомж</li> </ul>	<p>НЭДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС</p>	
5	Шилэн данс	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн төсвийн гүйцэтгэл</li> <li>- Нийслэлийн төсвийн мэдээлэл</li> <li>- Иргэдийн төсөв</li> </ul>	<p>НЭДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС</p> <p>НЭДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС</p>	Мэдээллийг тухай бүрд шинэчлэх
		<ul style="list-style-type: none"> <li>- Төсөл хөтөлбөр,</li> </ul>	<p>НЭДТГ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛТЭС</p>	
		<ul style="list-style-type: none"> <li>- Тайлан</li> </ul>	<p>НЭДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС</p> <p>НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР</p>	
		<ul style="list-style-type: none"> <li>-Шилэн дансны нэгдсэн цахим хуудас</li> <li>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</li> </ul>	<p>НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР ХОЛБОЛТ ХИЙХ</p>	
6	Нутгийн захиргааны байгууллагууд	<p>НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ</p> <p>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</p> <p>УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА</p> <p>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГАУУД</p> <p>НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАУУД</p> <p>НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ АЖ АХҮЙН ТООЦООТ БАЙГУУЛЛАГАУУД</p> <p>ДҮҮРЭГ</p> <p>ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАУУД</p> <p>ТӨСЛИЙН НЭГЖҮҮД</p>	<p>НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР ХОЛБОЛТ ХИЙХ</p>	
7	Улаанбаатар хотын статистик	Улаанбаатар хоттой холбоотой статистик мэдээллүүд байна	НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР	Мэдээллийг тухай бүр шинэчилж, баяжуулах, сонирхолтой байлгах.

8	Үйлчилгээнүүд	1. Нийслэлийн Замын хөгжлийн газар 2. Нийслэлийн Аялал жуулчлалын газар 3. Нийслэлийн Архивын газар 4. Нийслэлийн Байгаль орчны газар 5. Нийслэлийн Боловсролын газар 6. Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба 7. Нийслэлийн Мал эмнэлгийн газар 8. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар 9. Нийслэлийн Онцгой Байдлын газар 10. Нийслэлийн Нийгмийн халамжийн газар 11. Нийслэлийн Татварын газар 12. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар 13. Нийслэлийн Өмчийн харилцааны газар 14. Нийслэлийн Нийтийн тээврийн газар 15. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 16. Нийслэлийн Цагдаагийн удирдах газар 17. Нийслэлийн Эрүүл мэндийн газар 18. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 19. "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ 20. "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ 21. "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ 22. "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ 23. Хот байгуулалт, хөгжлийн газар 24. Хотын стандарт, хяналтын газар 25. Нийслэлийн Соёл, урлагийн газар	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар холболт хийх	
9	Өргөдөл, гомдол	- Өргөдөл, гомдол гаргах - Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	НЭДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс  НЭДТГ-ын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв	Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар хөгжүүлэлт хийх
10	Санал дэвшүүлэх	- Санал асуулга - Судалгаа - Санал дэвшүүлэх	НЭДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс  Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар хөгжүүлэлт хийх	Хүлээн авах, хянан баталгаажуу лах
11	Нийслэлийн замын түгжрэлийг харуулах булан		Замын хөдөлгөөний удирдлагын төв	Google maps-ийн тусламжтай харуулах цонх нэмэх. Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар